Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.05.02

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

2022 оны 5-р сарын 02

Өнгөрсөн сард ам.долларын ханш хүчтэй чангарсан нь алтны ханшийг 2.1%-иар унагах шалтгаан боллоо.

Тодруулбал, АНУ-ын төв банкнаас хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын хүрээнд бондын өгөөж нэмэгдэж ам.долларын ханш сүүлийн хоёр жил дэх хамгийн өндөр түвшинд байгаа юм.

Энэ нь хөрөнгө оруулагчдад ямар ч хүүгүй алтанд хөрөнгө оруулснаас өндөр хүүтэй бондыг сонгоход хүргэж байна.

Дэлхий нийтээр 5 сарын 3-нд эхлэх АНУ-ын Төв банкны бодлогын хуралд анхаарлаа хандуулж байна. Шинжээчдийн таамаглалаар бодлогын хүүг хагас нэгжээр нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Цаашид ч бодлогын хүүг нэмэх магадлал өндөр байна гэсэн мэдээлэллийн улмаас алтны ханш огцом унаад байгаа юм.

Нэгдүгээр улиралд АНУ-ын хөдөлмөрийн зардал сүүлийн 21 жилд хамгийн өндөр гарсан нь цалингийн инфляци нэмэгдэж, Холбооны нөөцийн мөнгөний бодлогын түрэмгий байр суурийг дэмжиж байгааг харуулж байна.

ДНБ-ий мэдээлэл болон ажил эрхлэлтийн мэдээлэл нь инфляц өндөр хэвээр байгааг харуулж байна. Энэ нь алтыг ерөнхийд нь дэмжиж байна.

Алтыг инфляцийн өсөлт, тодорхойгүй байдлаас хамгаалах хэрэгсэл гэж үздэг ч хүүгийн түвшин нэмэгдэж байгаа нь хүүгүй активыг эзэмших зардлыг нэмэгдүүлснээр түүнийг сонирхлыг бууруулж байна.

Мэдэгдэл: *Энэхүү судалгааны дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал: **2022 оны 5-р сарын 02**

Москвагийн зүгээс Европын орнуудыг байгалийн хийн төлбөрөө рублиэр төлөхгүй бол нийлүүлэлтээ зогсооно гэсэн шаардлага тавьсан. Тиймээс Европын холбооны орнуудын Эрчим хүчний яамны сайд нар даваа гарагт яаралтай хэлэлцээр хийх гэж байна.

Өнгөрсөн 7 хоногт Болгар, Польш улсууд хийн төлбөрөө рублиэр төлөхөөс татгалзсанаар ОХУ нийлүүлэлтээ зогсоосон.

Харин ХБНГУ компаниудад төлбөр төлөх боломжийг олгох комисс байгуулсан бол Унгар улс ОХУ-ын тавьсан шаардлагын дагуу төлбөрийг гүйцэтгэх боломжтой гэж мэдэгджээ.

Энэ сарын сүүлээр ЕХ-ны олон компани хийн төлбөрөө төлөх юм. Тиймээс ЕХ-ны орнуудын зүгээс ОХУ-ын эсрэг авсан хориг арга хэмжээг цуцлахгүйгээр шатахуунаа хээхэн үргэлжлүүлэн худалдаж авах талаар тодруулах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Москвагийн зүгээс байгалийн хийн худалдан авагчдыг Оросын хувийн эзэмшлийн Газпромбанкны дансанд евро эсвэл доллар байршуулж, рубльд хөрвүүлсний дараа худалдан авагчийн үүргээ биелүүлсэн гэж үзэхэд асуудалгүй гэж мэдэгдэв.

Учир нь ОХУ нь ЕХ-ны байгалийн хийн 40%, нефтийн импортын 26%-ийг хангадаг учраас Герман болон бусад улс орнууд эдийн засгийн хохирол амсахаас эмээж Оросын шатахууны импортыг огцом зогсоох уриалгыг эсэргүүцсээр ирсэн юм.

Төлбөрийг рублиэр хийх нь Оросын эдийн засгийг хориг арга хэмжээний нөлөөллөөс хамгаалахад туслах юм.

ОХУ 2 сарын 24-нд Украины нутаг дэвсгэрт халдсанаас хойш ЕХ-ны орнууд ОХУ-д 45 тэрбум гаруй евро буюу 47,43 тэрбум ам.долларыг байгалийн хий, нефтийн төлбөрт төлсөн гэж Эрчим хүч, цэвэр агаар судлалын төвийн судалгааны байгууллага тогтоожээ.

Энэ долоо хоногт болох уулзалтын өмнө болсон Комисс болон ЕХ-ны орнуудын хоорондын хэлэлцээрийн дараа ЕХ оны эцэс гэхэд Оросын нефтийн импортыг хориглох хандлагатай байна гэж дипломатууд мэдэгдэв.

Элчин сайд нар лхагва гарагт болох хурлаараа Москвагийн эсрэг Европын Холбооноос авах хориг арга хэмжээний зургаа дахь багц хуулийн төслийг хэлэлцэнэ.

Мэдэгдэл: *Энэхүү судалгааанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгааанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*